

МОНГОЛ УЛСЫН БУДДЫН ШАШНЫ ДАХИН СЭРГЭЛТИЙН УЧИР ШАЛТГААН БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*Л.Түмэнцэцэг**

Шарын шашин ХҮI зууны сүүлчээр Монгол оронд дэлгэрснээс хойш монгол үндэстний шүтдэг үндсэн шашин болж чадсан байна. ХҮШ зуунаас хойш энэхүү шашин улам дэлгэрч ХХ зууны эхэн үе болоход Халхын нутагт нийт 750 гаруй сүм хийд бий болж,¹ лам хуврагийн тоо 105.5 мянга болсон байна.² Буддын шашны төв Гандан хийд оршиж буй Их хүрээ Халх Монголын улс төр, эдийн засаг, соёлын төв болон хөгжжээ.

1921 онд Ардын хувьсгал ялсны дараа МАН-ын өөрийн үзэл баримтлал, Коминтерины шахалтаас үүдэн 1924 онд Жавзандамба хутагт таалал төгссөний хойно Хаант засаглалыг халж Бүгд Найрамдах улсыг байгуулжээ. Үүнээс хойш шарын шашныг дарж хавчин гадуурхан устгах бодлогыг хэрэгжүүлж нийт 700 гаруй сүм хийдийг нураан олон мянган шашны ном судрыг шатаажээ.³ Ингээд 1939 он гэхэд нэг ч сүм хийд үйл ажиллагаа явуулах эрхгүй болсон байна. Тухайн үед тус улсын хэмжээнд зөвхөн Гандан хийдэд арваад лам шашны үйл ажиллагаа явуулж, судалгаа хийдэг байлаа. Энэхүү байдал нь явсаар 1990 оны ардчилсан хувьсгалтай золгожээ. Ардчилсан хувьсгал нь Монгол Улсын ард түмэнд шашин шүтэх эрхийг олгосон бөгөөд түүнчлэн Монгол Улсын буддын шашин дахин сэргэж, хөгжих хандлага бий болжээ.

Нэг. Монголд буддын шашин дахин сэргэсэн шалтгаан

Өнөөгийн Монголын буддын шашны байдал 1990 оны өмнөх үетэй харьцуулахад ихээхэн өөрчлөгджээ. Сүм хийд, сүсэгтэн олны тоо ихээхэн нэмэгджээ. Арав гаруй жилийн хугацаанд ийнхүү хурдацтай хөгжсөн нь доорхи хэдэн зүйлээс шалтгаалсан гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Нийгэм өөрчлөгдөж шашин хөгжихөд тохиромжтой төрийн бодлого явуулсан. 1990 оноос хойш хөгжсөн ардчилсан нийгмийн тунхагласан нэг чухал зорилт бол уламжлалт соёлоо дахин сэргээх явдал юм. Энэхүү зорилтод Монголын уламжлалт шарын шашин багтана. 1992 оны 1 сарын 13-нд баталсан Монгол улсын шинэ үндсэн хуульд “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэж тодорхой заажээ.⁴ Түүнчлэн төр шашны харилцааг илүү сайн зохицуулахын үүднээс 1993 онд “Төр сүм хийдийн харилцааны хууль” баталжээ. Тус хуулинд монголын ард түмний эв найрамдал,

* Л.Түмэнцэцэг - Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн дэргэдэх Хөрш улс судлалын хүрээлэн, профессор

уламжлалт түүх соёлыг хүндэтгэж буддын шашны давуу эрхийг хүндэтгэн үзнэ. Гэвч энэ нь бусад шашин дэлгэрэхэд харшлахгүй хэмээн заажээ.⁵ Эдгээр байдлаас үзэхэд Монгол Улсын төр засаг шашнаа хөгжихийг дэмжиж хууль зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

Хоёрдугаарт, Ард түмний уламжлалт соёл иргэншил, шашнаа хүндэтгэх сэтгэл зүй нөлөөлж шарын шашин дахин сэргэх нөхцөл бий болсон байна. Мөн социалист нийгмийн үед шарын шашинд шударга бус хандсан нь шинэ цаг үед дахин сэргэн мандахад түлхэц болсон байна. Түүхэн байдлаас үзвэл буддын шашин нь монголчуудын амьдрал, зан үйл, түүх соёлд асар их нөлөө үзүүлсэн төдийгүй монголчууд шарын шашныг онцгойлон шүтдэг байсан байна. Иймд ард түмний шашин шүтэх эрхийг олон арван жилийн турш хорьж байсан нь уламжлалт шашнаа сэргээн мандуулах хүсэл эрмэлзлийг улам бадруулсан байна. Хэдийгээр жараад наснаас доош хүмүүсийн ихэнх нь шашны онол суртлыг сайтар мэдэхгүй ч уламжлалт шарын шашны сэтгэлгээ сэтгэлийн гүнд хадгалагдсаар байжээ. Учир нь ардын хувьсгалаас өмнө өрх бүрээс нэг хүүхэд нь лам болж хийдэд шавилан суудаг байв. Гэвч 30-аад оны үеэс хилсээр хэлмэгдэн зовжээ. Иймд монголчууд уламжлалт шарын шашнаа дээдлэн дахин сэргээхийг чин сэтгэлээсээ хүссэн байна.

Гуравдугаарт, Нийгмийн тогтворгүй байдлаас үүдэн шашин сэргэх болсон байна. Нийгмийн тогтворгүй байдлаас шалтгаалан олон төрлийн үзэл санааны урсгал орж ирсний улмаас үзэл санааны замбараагүй байдал бий болж нийгмийн зан суртал эвдэгдэж, гэмт хэрэг олширч, хүүхэд залуучууд гэмт хэрэгт хамрагдах нь ихсэж, ажилгүйдэл ядуурал зэрэг зарим нийгмийн асуудал олширсноос хүмүүс сэтгэл санааны тайвшралыг олохоор дахин шарын шашны сүм хийдийг зорих болсон байна.

Дөрөвдүгээрт, Улс төрийн намууд мөн шашин сэргэн мандахад багагүй нөлөө үзүүлж байна. Олон намын тогтолцоо бүрэлдсэнээс болж улс төрийн намууд бий болж, эдгээр намууд хоорондоо өрсөлдөн олны итгэл хүндэтгэлийг олохын тулд шарын шашныг ашиглаж байна.

Тавдугаарт, Гадаадын шашны хүчин Монгол Улсын буддын шашин хөгжихөд нөлөөлж байна. Монголын шарын шашин нь Төвдөөс үүсэлтэй. ХҮИ зуунаас ХХ зууны эхэн хүртэл Монгол болон Төвдийн шашны хооронд нягт харилцаатай байсан. 1573 онд Түмэдийн Алтан хан Төвдөөс Содномжамц ламыг Хөх нуурт залж түүнд “Далай лам” хэмээх цол өргөмжилжээ. Түүнээс хойш IV Далай лам Монгол нутагт тодорч, бусад нь Төвдөөс тодорч байна. Халх Монголын шашны тэргүүн болох III-ҮIII Жавзандамба хутагт Төвдөөс тодорч байв. Шашны харилцаа маш нягт тул хэдэн зуун жилийн турш утга зохиол, урлаг, зан үйл харилцан нөлөөлж, олон нийтлэг зүйлийг бий болгожээ. 1990 оноос хойш Энэтхэгийн Дармасалад байрладаг Далай ламын бүлэглэлтэй дотно

холбоо тогтоож арав гаруй жилийн хугацаанд олон залуу лам нарыг Энэтхэгт шашны сургуульд сургасан байна. ХИҮ Далай лам 1990 оноос хойш нийтдээ 4 удаа Монгол Улсад айлчилж, Монголын буддын шашны хөгжилд үлэмж нөлөө үзүүлжээ. Үүнээс гадна Монгол Улсын буддын шашны ертөнц дэлхийн шашны байгууллагуудтай харилцаагаа өргөжүүлж гадаадын шашны байгууллагууд эд материалын тусламж үзүүлж байв. Жишээ нь: Японы буддын шашны байгууллага Монголын буддын шашныг хөгжүүлэхэд хөрөнгө мөнгөний тусламж үзүүлж байв. Иймээс Монголын буддын шашны хөгжилд гадаадын буддын шашны байгууллага багагүй нөлөө үзүүлсэн байна.

Зургадугаарт, Бусад шашны урсгал Монгол Улсад дэлгэрсэн нь шарын шашны бусад шашинтай өрсөлдөх чадвараа сайжруулахыг шаардсан байна. Өөрчлөлт шинэчлэлийн дараа харийн шашны урсгал Монгол Улсад нэвтэрч шашин хоорондын өрсөлдөөн бий болсон байна. Иймд буддын шашин нийгмийн өөрчлөлтийг дагалдан өөрчлөлт хийх хэрэгтэй хэмээн Монгол Улсын ерөнхийлөгч дурьдсан бөгөөд буддын шашин нь бусад шашинтай өрсөлдөх чадвараа сайжруулахаар чармайж байна.

Долдугаарт, Буддын шашин ийнхүү дахин сэргэж чадсан нь Монголын байгаль орчин, нүүдлийн соёл иргэншил, зан үйлтэй нягт уялдаж чадсантай холбоотой юм. Уур амьсгал эрс тэс, өвөл нь хүйтэн зэрэг цаг уурын онцлогтой энэ нутагт буддын шашин хэдэн зуун жилийн хугацаанд нүүдлийн соёл иргэншилтэй уялдаж байгаль орчинтой зохицон хөгжиж чадсан байна. Энэ нь монголчууд бурхан шашнаа эдүгээ хүртэл хадгалж ирсний нэгэн чухал шалтгаан болно. Үүнээс үзэхэд буддын шашны Монгол Улсад дахин сэргэсэн нь нүүдлийн уламжлалт амьдарлын соёл иргэншилтэй нягт холбоотой хэмээн үзэж болно.

Хоёр. Монголын буддын шашны өмнө тулгамдаж буй асуудал

Хэдийгээр арав гаруй жилийн хугацаанд зуу гаруй сүм хийдээ сэргээж, сүсэгтний тоо ихээр нэмэгдсэн боловч тулгамдсан асуудлууд нэлээд байна. Буддын шашны тулгамдаж буй асуудал олны анхаарлыг татаж байна. Үүнд:

1. Сүм хийдийн тоо тасралтгүй нэмэгдэж байгаа боловч хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллага ч олон байна. Зарим сүм хийд нь ном судар, шашны зан үйлд хэрэглэх эд зүйл дутмаг бөгөөд энэ нь сүсэгтэн олны шаардлагад нийцэхгүй байна.

2. Буддын шашин хэрхэн одоогийн нийгмийн амьдралтай зохицох асуудал оршиж байна. Буддын шашин анх Монголд дэлгэрэхэд бөөгийн шашин болон уламжлалт соёлтой уялдаж хөгжиж чадсан. Гэтэл өнөөгийн нийгэмд дахин сэргэн мандахад багагүй бэрхшээл учирч байна.

Хуучинсаг арга барил нь өнөөгийн нийгмийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Бусад шинээр дэлгэрч буй шашинтай харьцуулбал буддын шашин нь хоцрогдмол, шинэлэг тал дутмаг тул Монгол Улсын ерөнхийлөгч, буддын шашны тэргүүн нар энэ асуудлыг чухалчлан үзэж шашинд өөрчлөлт шинэчлэл хийх талаар анхаарч ажиллаж байна.

3. Лам хуврагийн боловсролыг дээшлүүлэх асуудал оршиж байна. Учир нь өнөөгийн Монгол Улсын лам нарын дунд жинхэнэ эрдэм номтой лам хувраг цөөн байна. Иймээс зарим сүм хийд нь үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрч байна. Зарим лам нар нь сахил санваараа сайтар сахихгүй байна. Эдгээр байдал нь шашны нэр хүнд, ирээдүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

4. Бусадхарийн шашинтай зэрэглэн орших асуудал тулгамдаж байна. 1990 оноос хойш олон шашны урсгал Монголд орж ирснээс эхлэн Буддын шашны давуу байр сууриа хамгаалах шаардлагатай болсон. Шашин хоорондын онол, үзэл санаа өөр учир шашин хооронд зөрчил үүсч эхэлсэн байна. Хэдийгээр эдгээр нь төрийн зохицуулах асуудал боловч буддын шашны хувьд авч үзвэл мөн л тулгамдсан чухал асуудал юм.

Гурав. Дүгнэлт

Дээрхи байдлаас үзэхэд Монголын буддын шашин хэдийгээр ойрын жилүүдэд дахин сэргэж хурдацтай хөгжиж байгаа ч шинэ цаг үетэй хэрхэн зохицох, өөрчлөлт шинэчлэлт хийх, хүмүүсийн оюун санааны хэрэгцээг хангах, шашны идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж нийгмийн амгалан тайван байдлыг хангах зэрэг олон асуудлууд оршиж байна. Эдгээрийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. С. Пүрэвжав “Монгол улсын шашины товч түүх” УБ., 1978. тал 99.
2. 趙臣爲主編《世界宗教總覽》，東方出版社，1996年6月，北京第二次印刷，第524頁。
3. Д. Чойжамц “Монгол улсын шашины өнөөгийн байдал тулгамдсан асуудал”, “Төр сүм хийдийн харилцаа одоо үед” УБ., 1998. тал 23.
4. Монгол Улсын Үндсэн хуулийн 9.1-д.
5. Монгол Улсын төр сүм хийдийн харилцааны хуулийн 2-р бүлэг 4.2-г.